

“ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛ”  
SOCIALIZATION WORK IN PRISONS



П.Баярбаатар

*Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд хурандаа*

**Хураангуй:** Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны үр нөлөө, өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэн судлахын тулд удирдлагын дэмжлэг, тусламж, нийгэмшүүлэх орчин нөхцөл, мэргэжлийн үйл ажиллагааны нөлөөлөл, зохион байгуулж буй үйл ажиллагаа, нийгмийн ажилтны хүний эрхийн мэдрэмж, хандлагад үнэлгээ өгөх замаар дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгоход чиглэгдсэн дүгнэлт, санал дэвшүүлэх зорилго тавилаа.

**Abstract:** In order to analyze the results of the socialization activities of prisoners and the current situation, the aim was to analyze and evaluate the support provided by the administration, the socialization environment, the effectiveness of professional activities, the work being organized, the relationships and attitudes of social workers and prison staff, and to make conclusions and suggestions for further improvement.

**Түлхүүр үг:** суллагдахад бэлтгэх, хорих байгууллагын нийгмийн ажил, хоригдлыг нийгэмшүүлэх, засрал хүмүүжил, сургалт.

**Key words:** prisoner, preparing for release from prison, social work in prisons, rehabilitation of prisoner, rehabilitation and training

УДИРТГАЛ

Хүн төрөлхтөн өнөөг хүртэл “гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийн өмнө байгалийн гамшгаас дутуугүй айн чичирч амь нас, эд хөрөнгөө хамгаалахын тулд төрөл бүрийн оролдлого хийсээр ирсний” (Мөнх-Эрдэнэ, 2021, хууд. 38) зэрэгцээ энэхүү оролдлогыг хамгийн үр дүнтэй тэмцэл нь хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх буюу “нийгэмд эргэн нэгтгэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх явдалд анхаарах” (Гантулга, 2015) хэмээн үзсэн.

Хоригдлыг нийгэмшүүлэх боломжтой эсэх талаар эрдэмтэн судлаачид өөр өөрийн байр сууринаас ханддаг бөгөөд боломжгүй мэт эргэлздэг судлаачид цөөнгүй байдгийг нуух юун билээ. Өөрөөр хэлбэл, насанд хүрсэн хүнийг нийгэмшүүлэх,

тэр дундаа гэмт хэрэгтэн бие хүнийг нийгэмшүүлэх нь боломжгүй хэмээн их, бага хэмжээний эргэлзээтэй байдгийг дурдах нь зүйтэй юм. Тэгвэл нийгэмшил гэсэн ойлголтыг олон өнцгөөр тайлбарлан ирсний дотор академич Н.Бэгз “хувь хүний бүлэг хүмүүстэй буюу нийгэмд зохицохын тулд нийгмийн хэм хэмжээ, үзэл баримтлал, эерэг хандлага, харилцааны ур чадвар эзэмших тасралтгүй үйл явцыг хэлнэ” (Бэгз, 2021, хууд. 103) хэмээн тодорхойлсон нь хорих ял эдэлж буй бие хүнийг нийгэмшүүлэх ажил, энэхүү үйл ажиллагааны үр нөлөөг тооцох ач холбогдлыг томъёолсон гэж үзэж судлаачийн байр сууринаас санал нэгдэж байдаг.

“Өөрөөр хэлбэл “хоригдол” -ыг нийгэмшүүлэх буюу нийгэмд эргэн нэгтгэх, нийгмийн гишүүн болгох нь нийгмээс тогтоосон хэм хэмжээ буюу хуулийг сахин мөрдөх дадал хэвшилтэй болох, нийгмийн өмнө тодорхой үүрэг хүлээх, хүнтэй харилцах харилцаанд эерэг өөрчлөлт гарахаас гадна хүнлэг сэтгэлтэй, зөв зан үйлтэй дадал хэвшилтэй болж төлөвшихөд нь чиглэгдэх үйл явц гэж ойлгож болох юм” (Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, 2024).

Гадаад, дотоодын нийгмийн ажлын шинжлэх ухааны зарим эрдэмтэд (Clausen 1968; Goslin 1969; Watson 1924; Н.Бэгз 2022) нар “нийгэмшүүлэх нь сэтгэл судлал социологи, социологи ба антропологи, нийгэм ба байгалийн шинжлэх ухааны хоорондын маргаан, аргументуудын баялаг түүхтэй учраас нийгмийн шинжлэх ухааны салбар хоорондын дэд салбар юм гэж үзээд тус ойлголтын талаар тайлбарлахдаа хүн амьдралын бүхий л хугацааны туршид өөртөө дадал чадвар бий болгох буюу суралцах, хандлага төлөвшүүлэх, үнэнч шударга байдал, итгэл үнэмшлийг суулгах замаар амьдрал, үйл ажиллагаандаа амжилт гаргах, өөрчлөлтийг хийх боломжтой үүнийг чиглүүлэх нь зүйтэй юм” (Matejkowski, 2014) хэмээн бичиж тэмдэглэсэн байна.

Мөн нийгэмшүүлэх гол арга зам нь “хүн хоорондын идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаанаас үүдэлтэй гэж үзэх үндэслэлтэй бөгөөд гурван арга замаар явагддаг гэжээ. Үүнд нэгдүгээрт, амьдарч буй нийгэм, улс орны соёлын нөлөөгөөр аяндаа явагдах; хоёрдугаарт, тодорхой орчин нөхцөлд явагдах буюу хүн өөрт тулгараад байгаа асуудлыг эдийн засаг, эрх зүй, халамж үйлчилгээний хүрээнд шийдвэрлэх явцдаа туршлага хуримтлуулах замаар нийгэмшинэ. Өөрөөр хэлбэл хүний харьяалагдаж байгаа бичил орчин, сонгон эзэмшсэн мэргэжил, хамт олны нөлөөгөөр нийгэмших; гуравдугаарт, хүнийг хөгжүүлэх, төлөвшүүлэх зорилго, чиглэл, зохион байгуулалттай үйл ажиллагаагаар дамжин нийгэмших гэж тодорхойлжээ” (Мөнх-Эрдэнэ, Гэмт хэрэг судлалын онол, 2021, хууд. 148)

Ийнхүү нийгэмшлийн үр дүнд хүн нийгмийн хэвийн гишүүн болж төлөвшдөг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл энэхүү үйл явцыг агуулгын хувьд авч үзвэл:

- “хүйсийн сэтгэл зүйтэй холбоотойгоор эрэгтэй, эмэгтэй хүний зан төлөв, тус бүрийн болон хамтран гүйцэтгэх үүргийг эзэмших;

- нийгэмд баялгийг бүтээгч, баялгийг хүртэгч байхын тулд мэргэжлийн ур чадварыг эзэмших;
- нийгмийн анхдагч бүлэг болох гэр бүлийн гишүүний үүрэг хариуцлага хэм хэмжээний талаарх ойлголт төлөвшилтэй болох;
- нийгмийн харилцааг зохицуулж буй хууль, дүрэм журмыг сахидаг иргэншсэн хүн болж төлөвших зэргийг дурдаж болно.

Монгол Улсын хувьд нийгэмшүүлэх энэхүү үзэл баримтлалд тулгуурлан нийгэмд тогтоосон хэм хэмжээг ноцтойгоор зөрчсөн хүн буюу хоригдлыг нийгэмшүүлэх” (Болдбаатар & Мөрөн, 2016, хууд. 11) үйл ажиллагааг нийгмийн ажлын үйлчилгээгээр дамжуулан нийгэмд эргэн нэгтгэх асуудал нь хууль зүйн хувьд тусгалаа олжээ. Энэ нь Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 -д зааснаар эрүүгийн хариуцлагын зорилго, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нийгэмшүүлэх ажлыг зохицуулалтаар тус тус илэрч байна.

Учир нь эрүүгийн хариуцлагын зорилгод хорих ялаар шийтгүүлсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, дахин нийгэмшүүлэх замаар хууль, дүрэм журмыг мөрддөг, нийгмийн иргэншсэн гишүүн болгоход хорих байгууллагад зохион байгуулж буй нийгэмшүүлэх ажил голлох нөлөөтэй юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218 дугаар зүйлд зааснаар хоригдол буюу гэмт хэрэгтэн бие хүнийг хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ хэмээн хуульчилсан гэдгийг дурдах нь зүйтэй юм.

## ҮНДСЭН ХЭСЭГ

Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын талаар дурдахын өмнө субъектийн онцлогийг анхаарах нь чухал юм. Учир нь “гэм буруутай нь шүүхийн шийтгэх тогтоолоор нотлогдож хорих ялаар шийтгэгдсэн буюу хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл үйлдсэн бие хүн” (Matejkowski, 2014, хууд. 245) -ийг нийгэмд эргэн нэгтгэх асуудал юм.

Криминологийн шинжлэх ухаанд “гэмт хэрэгтэн бие хүний тухай авч үзэхдээ гэмт хэрэг үйлдсэн мөчөөс түүнийг засарч хүмүүжих үе хүртэлх хугацааг хамаарна гэж үздэг нь ч учиртай. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтэн гэдэг ойлголт нь бие хүн гэсэн ерөнхий социологийн ойлголттой нягт холбоотой. Нийгмийн шинжлэх ухааны сэтгэлгээний түүхэнд бие хүний тухай асуудлыг хэзээ ямагт өргөн хүрээтэй сонирхон судалж ирсэн төдийгүй Карл Маркс хүн жинхэнэ чанартаа нийгмийн бүх харилцааны цогцолбор юм” (Жанцан, 2000, хууд. 41) гэж үзэж байсантай холбон тайлбарласан байдаг.

Ийнхүү хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил нь өвөрмөц онцлогтой бөгөөд гэмт хэрэгтэн бие хүнд чиглэгдэх бөгөөд хорих ангид ирсэн үеэс эхлэн нийгмийн амьдралд дасан зохицох чадвар, бие даан хөгжих, өөрийгөө танин мэдэх, бусдаас хараат бусаар амьдрах болон үйл ажиллагаанд оролцох чадвар, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн гажуудсан зан үйлийг илрүүлэх, харилцааны ур чадвар эзэмшүүлэхэд чиглэгдсэн нийгэмшүүлэх ажлыг хоригдол бие хүнийг судалсан судалгаанд үндэслэсэн төлөвлөгөөт мэргэжлийн үйлчилгээ, нөлөөллөөр дамжуулан хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай юм.

Хэдийгээр эрх зүйгээр зохицуулсан хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагаа нь зарим нэгэн судалгаа, тоо баримтаас харахад төдийлөн хангалттай түвшинд хэрэгжихгүй байна хэмээн судлаачийн зүгээс үзэх үндэслэл байна. Учир нь “Хорих ял эдлүүлэх албаны Тоо бүртгэл, дүн шинжилгээний хэлтсийн 2024 оны судалгаанд гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдэгсдийн тоо өсөх хандлагатай, хорих ял эдлээд суллагдсан иргэдийн зүгээс давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байна” . Энэ нь 2 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 1011 буюу 22.5 хувь, 3 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 548 буюу 13 хувийг 4-10 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 805 буюу нийт хоригдлын 17.9 хувийг бүрдүүлсэн нь дахин гэмт хэрэг үйлдэгчид нийт хорих ял эдлэгсдийн дунд голлох эзлэхүүнтэй буюу 54.6 хувь байгаа нь энэхүү асуудалд задлан шинжилгээ хийх хэрэгцээ байгааг илэрхийлж байна.


Бид хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны үр нөлөөнд шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх зорилгоор нээлттэй, хаалттай, эмэгтэйчүүдийн хорих ангийн 120 хоригдлыг түүвэрлэн авч 7 багц асуудлын хүрээнд 45 асуумж бүхий судалгааг авсан. Судалгааны түүврийн насны хувьд 8.3 хувь нь 18-25 настай, 27.5 хувь нь 26-35 настай, 30.8 хувь нь 36-45 настай, 27.5 хувь нь 46-60 настай, 5.8 хувь нь 61-80 настай хоригдол хамрагдсан. Харин судалгааны түүврийн 68.3 хувь нь дээд, 16.7 хувь нь бүрэн дунд, 11.7 хувь нь суурь, 3.3 хувь нь бага боловсролтой байсан бол хөдөлмөр эрхлэлтийн хувьд 6.7 хувь нь төрийн албанд, 55.8 хувь нь хувиараа, 25 хувь нь хувийн хэвшилд, 12.5 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй хоригдол судалгаанд хамрагдсан.

Ерөнхий мэдээллээс харахад судалгааны түүврийн насны байдал Монголчуудын насны ангилал болон сэтгэл зүйч Эрик Эриксоны бие хүний сэтгэл зүйн хөгжлийн онолоор ид нас буюу хөдөлмөрлөх, хийж бүтээх, залуучууд, нэг үгээр хэлэхэд хамгийн чухал, шийдвэр гаргах үүрэгтэй үе дээрээ байгааг харж болно. Боловсролын хувьд дийлэнх буюу 68.3 хувь нь дээд боловсролтой, мэргэжилтэй байгаагаас гадна 90 орчим хувь нь ял эдлэхийн өмнө хөдөлмөр эрхэлж байсан.

Бид судалгаанд оролцогсдоос хоригдлыг нийгэмшүүлэх ажлын орчин нөхцөлийг тодорхойлохын тулд сургалтын танхим, номын сан, ганцаарчлан уулзах өрөө, бие даан өөрийгөө хөгжүүлэх орчин, хорих өрөө, биеийн тамирын өрөө, талбай зэрэг

асуудлын талаар багцлан асууж үнэлгээг 5 түвшинд гаргахад дараах үр дүн үзүүлсэн.

Зураг 1. Хоригдлыг нийгэмшүүлэх орчин, нөхцөлийн талаарх үзүүлэлт




Судалгааны түүврийн 16.7 хувь нь нийгэмшүүлэх орчин нөхцөл доогуур түвшинд, 33.3 хувь нь дунд, 50 хувь нь хангалттай сайн түвшинд байна гэж үнэлсэн байна. Нийгэмшүүлэх орчин нөхцөлийн талаар доогуур үнэлгээ үзүүлсэн асуудлын талаар задлан үзвэл 42.5 хувь нь ганцаарчилсан зөвлөгөө, нийгмийн ажлын үйлчилгээ авах нөхцөл бүрдээгүй муу гэж үзсэн бол 20.8 хувь нь дунд, 36.6 хувь нь сайн гэж үнэлсэн байна.

Мөн судалгааны түүврийн 50 хувь нь өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдээгүй гэж үзсэн бол 14.2 хувь нь дунд зэрэг, 35.8 хувь нь сайн бүрдсэн гэж хариулжээ.

Судалгаанд оролцсон хоригдлын 57.5 хувь нь нийтийн сургалтын танхим маш сайн, 55 хувь нь номын сангийн тохижилт сайн, 51.7 хувь нь хорих өрөө тохилог сайн байгаа, 46.7 хувь нь биеийн тамирын өрөө, талбай сайн байна гэсэн үзүүлэлттэй байна.

Энэхүү тоон үзүүлэлтээс харахад “хоригдолтой ганцаарчлан уулзах хэрэгцээ их байдаг төдийгүй нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид нь хоригдолд ганцаарчилсан уулзалт, зөвлөгөөгөөр хоригдлын харилцааны ур чадварыг тодорхойлох, сэтгэл зүйн нөхцөл байдалд тохирох мэдээлэл өгөх, чиглүүлэх, зөвлөн туслах, дэмжин хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төдийгүй энэхүү мэргэжлийн үйл ажиллагааг дутмаг явуулснаар хоригдол бусад хүнтэй харилцах явцад зөрчилдөх нь ихсэх, амьдралын утга учир, үнэт чанарын талаарх мэдрэмж сулрах буюу шоронд дасах, өөртөө итгэх итгэл алдрах буюу нийгмийн айдас нэмэгдэх, бусад хүний санаа бодол, мэдрэмжид хайхрамжгүй хандах буюу хүнлэг чанар буурах, сэтгэл хуваалцах байдлаас төвөгшөөх буюу зожгирох зэрэг шинж тэмдэг илэрч нийгэмшүүлэх ажиллагаанд саад учирч болзошгүй” (Баярбаатар, 2024) байдаг.

Зураг 2. Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагааны талаарх үзүүлэлт




Нийгэмшүүлэх ажлын үндсэн суурь нь нийгмийн ажилтны хэрэгжүүлж буй мэргэжлийн үйл ажиллагаагаар дамжин илэрдэг. Энэхүү ажлыг бид хоригдол суллагдан гараад хаана хандах, тусламж дэмжлэг хэрхэн авах талаар мэдээлэл ойлголттой болсон байдал, гэр бүл, найз, нийгмийн байгууллагад холбон зуучлах үйлчилгээ үзүүлдэг эсэх, хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил таны эрэлт хэрэгцээг хангаж чадаж буй эсэх, ял эдлэх хугацаандаа нийгэмд хэрэгцээт боловсрол, мэдлэгийг авч чадаж байгаа, ял эдлэх үеийн болон суллахад бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт авах зорилготойгоор авсан.

Энэхүү асуудлын хүрээнд судалгааны түүврийн 51.7 хувь нь нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд доогуур үнэлгээ өгсөн буюу хангалтгүй гэсэн бол 48.3 хувь нь сайн маш сайн ажиллаж байгаа гэсэн үр дүн үзүүлсэн.

Тэгвэл нийгмийн ажилтны хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн зүгээс доогуур үнэлгээ өгч байгаа нь нэг талаас мэргэжлийн үйл ажиллагаанд мэргэжлийн бус алба хаагч ажиллаж байгаатай шууд холбоотой гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь судлаачийн зүгээс шинжилж үзэхэд хорих байгууллагад ажиллаж буй “59 нийгмийн ажилтнаас эрх зүйч мэргэжилтэй алба хаагч 61 хувь, багш, эдийн засагч мэргэжилтэй алба хаагч 10.1 хувь, нийт нийгмийн ажилтны 71.1 хувийг эзэлж байгаа бол нийгмийн ажилтан мэргэжилтэй алба хаагч ердөө 28.9 хувийг бүрдүүлж байна” (СНСЗХ, 2023.09.18).

Харин бусад мэргэжилтэй нийгмийн ажилтны ажилдаа дадлагажин мэргэшиж буй байдлыг харахад 40.1 хувь нь энэхүү албан тушаалд 1 жил хүртэл ажиллаж байгаа, 23.8 хувь нь 2 жил хүртэл ажиллаж байгаа, 19 хувь нь 3-6 жил нийгмийн ажилтнаар ажиллаж байгаа судалгаа байна.

Зураг 3. Хорих байгууллагаас хэрэгжүүлж буй нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний талаарх үзүүлэлт



Энэхүү үзүүлэлтийг гаргахдаа нийгмийн ажилтны мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлага, хорих ангийн бусад алба хаагчийн харилцаа хандлага, харуул хамгаалалтын ажилтны шаардлага, хорих ангийн удирдлагын зүгээс дэмжлэг, тусламж үзүүлж буй байдал, хамт хоригдож хоригдлын үзүүлж буй сөрөг нөлөөлөл зэрэгт өгсөн үнэлгээг нэгтгэн хорих байгууллагаас хэрэгжүүлж буй нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг үнэлсэн.

Судалгааны түүврийн 58.3 хувь нь хорих байгууллагаас хэрэгжүүлж буй нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг муу буюу хангалтгүй гэж үнэлсэн бол 34.2 хувь нь сайн, 6.7 хувь нь маш сайн гэж үнэлсэн үзүүлэлттэй байна.

Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөнд өгсөн үнэлгээний ерөнхий үзүүлэлтийг шинжлэн үзвэл 38.4 хувь нь нийгмийн ажилтны мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлага, нийгэмшүүлэх ажлыг хангалтгүй гэж үзсэн бол 52.6 хувь нь хорих ангийн бусад алба хаагчийн харилцаа, хандлага муу, хорих ангийн удирдлагын зүгээс тусламж дэмжлэг үзүүлдэггүй гэж 20.9 хувь, хамт хоригдож буй хоригдол нийгэмших үйл явцад нөрөг нөлөө үзүүлдэг гэж 35.5 хувь үзсэн байна.

## ДҮГНЭЛТ

Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд хорих ангид бүтээн байгуулалт ихээр өрнөж хоригдлын номын сан, сургалтын танхим, хорих өрөөний нөхцөл сайжирсан боловч нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэг хэсэг болох ганцаарчлан зөвлөгөө, уулзалт явуулах буюу хоригдол тус бүрийн онцлогт тохируулан хүргэх орчин нөхцөл дутмаг, бүрдээгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулагдаж буй тоо мэдээ өндөр, олон хоригдлыг хамруулж байгаа хэдий боловч дахин гэмт хэрэг үйлдэж буй хоригдол нийт хорих ял эдлэгсдийн 52.6 хувиас буурахгүй байгаа нь хорих ангид зохион байгуулагдаж буй нийгэмшүүлэх ажил, сургалт нь оновчтой бус, хувь хүнд нийцсэн, харилцааны ур чадварт тохирсон хөтөлбөр хэрэгжүүлээгүйтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй байна.

Нөгөөтээгүүр хоригдлыг нийгэмшүүлэх үйлчилгээ, сургалт зохион байгуулж буй нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь мэргэжлийн бус, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх дадлага туршлагагүй байгаад анхаарах цаг болсон байна.

Иймд хоригдолд явуулж буй сургалт, нийгэмшүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн судалгаа, шинжилгээний ажил хийх чадварыг хөгжүүлэхэд анхаарах, мэргэшүүлж давтан сургах, дадлага туршлагатай мэргэшсэн нийгмийн ажилтны боловсруулсан хөтөлбөр, тэргүүн туршлагыг практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хоригдлын нийгэмшсэн байдлыг үнэлэх үнэлгээ, баллын системийг боловсруулан үнэлж, үр дүнгээс шалтгаалан суллах эсэх асуудлыг шийдвэрлэж байх хэрэгцээ, шаардлага байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Matejkowski, T. J. (2014 оны 2 3). Prison Social Work. <https://oxfordre.com/>:  
<https://oxfordre.com/-ээс> Гаргасан

Аванесов, Г. (1980). Криминология и социальная профилактика. Москва.

Баярбаатар, П. (2024). Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт. Улаанбаатар.

Болдбаатар, Ж., & Мөрөн, Д. (2016). Эрүүгийн эрх зүй. Улаанбаатар.

Бэгз, Н. (2021). Хүний хөгжил нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар.

Гантулга, Н. (2015). Ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаа дахь хамтын оролцоо. Хууль сахиулахуй сэтгүүл /тусгай дэвтэр/.

Жанцан, Н. (2000). Криминологи. Улаанбаатар.

Мөнх-Эрдэнэ, Б. (2021). Гэмт хэрэг судлалын онол. Улаанбаатар.

Мөнх-Эрдэнэ, Б. (2021). Гэмт хэрэг судлалын онол. Улаанбаатар.

СНСЗХ. (2023.09.18). Нийгмийн ажилтан сэтгэл зүйчийн мэргэжлийн судалгаа. Улаанбаатар.

Ц.Очгэрэл. (2017). Хорих байгууллагын аюулгүй байдал. Улаанбаатар.

ШШГЕГ. (2022, 4 22). Тайлан бодит биелэлтийн мэдээ. Retrieved from ХӨТЯЭА.